

БАТЛАВ.УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.НАРАНПҮРЭВ

Огноо: 2020.04.29

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН ЖОЛООЧИЙН
ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ
ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр: АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН ЖОЛООЧИЙН
ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Тендер
шалгаруулалт/
гэрээний дугаар: УДШ/2020/01

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр

Тендер шалгаруулалтын журам: Харьцуулалтын арга
Тендерийн дугаар : УДШ/2020/01

Улсын Дээд шүүх нь эрх бүхий тендерт оролцогчдоос АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ-ын үйлчилгээ гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 14-ны 10:00 цагаас өмнө дор дурьдсан хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 10:30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: 15170. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн
гудамж, Улсын Дээд шүүхийн байр 401 тоот
Харилцах утас: 263138

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2 Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрөл
Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м() бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:
 1. Дуудлагын оператортай байх
 2. Шуурхай албаны машин 24 цагаар ажилладаг байх
2. Тендерийн иж бүрдэл
 - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (г) Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл/гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/
 - (д) Хохирол нөхөн төлбөр төлсөн байдлын жагсаалт/2019.01.01-2019.12.31-ны хооронд /
 - (е) Байгууллагын танилцуулга
 - (ё) Өөрийн байгууллагын гэрээний загвар
 - (ж) Санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан 2019 он
3. Тендерийн үнэ
 - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Алдааг залруулах
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу

гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А.ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|--|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
|-------------------|---|

- | | |
|--------------------------------------|--|
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|--------------------------------------|---|
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| 13. Алданги | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. Гэрээг цуцлах
- 17.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын санаачлагаар гэрээ цуцлагдаж болно.
- 17.2. Талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргавал нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 17.3. Гэрээг цуцлах санал хүлээн авсан тал нь хариуг хүндэтгэх шалтгаангүйгээр ирүүлээгүй бол гэрээ цуцлах саналд заасан өдрөөс эхлэн гэрээг цуцласанд тооцно.
- 17.4. Даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл гэрээний үлдсэн хугацаанд ногдох даатгалын хураамжаас даатгуулагчийн авсан нөхөн төлбөр, тухайн даатгалтай холдбогдон гарсан зардлыг хасч үлдэх хэсгийг Даатгуулагчид эргүүлэн олгоно.
- 17.5. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.6. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

18. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

19. Гүйцэтгэлээс чөлөөлөх

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон

түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг
гүйцэтгэгчид төлнө.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

4.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар : Авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, УДШ/2020/01

4.2 Ажил нь Авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгал-аас бүрдэнэ.

Жолоочийн хариуцлагын даатгалын эрсдэл:

-Жолооч нь авто тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь насанд учруулсан хохирол

- Жолооч нь авто тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол

- Жолооч нь авто тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эд хөрөнгөнд учруулсан хохирол

Авто тээврийн хэрэгслийн даатгалын эрсдэл:

- Зам тээврийн хөдөлгөөнд оролцож байх үеийн бүх төрлийн эрсдэл
- Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Байгалийн бүх төрлийн эрсдэл.
- Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Барилга, сантехникийн эрсдэл/зогсоол талбай, гаражид байх үеийн дулаан сантехникийн осол, барилгын нуралт / Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Шилний эрсдэл /Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үед/-Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Өөрийн санаандгүй үйлдлээс гарах эрсдэл.- Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Зогсоолд байрлуулах үеийн эрсдэл.-Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Биет зүйл дээрээс унах эрсдэл:гэрлийн шон,самбар г.м зүйлс дээрээс унах эрсдэл.- Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Мал, амьтнаас учруулах эрсдэл.- Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Жолоо шилжүүлсэн үед гарах эрсдэл.-Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Гал түймэр, дэлбэрэлтийн үеийн бүх төрлийн эрсдэл-Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Шилний эрсдэл /Зам тээврийн хөдөлгөөнд оролцоогүй үеийн/ Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Толины эрсдэл. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Гараж болон зогсоол талбайд байх үед учирч болох эрсдэл. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл:замын хөдөлгөөний бус. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Хулгайн сэдлээр үүссэн хохирол. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

- Бүрэн хулгайн эрсдэл/тээврийн хэрэгслийг бүхэлд нь хулгайд алдах.эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Хэсэгчилсэн хулгайн эрсдэл/ автомашины доторх үйлдвэрээс суурилуулсан эд анги хулгайд алдагдах/. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Толины хулгайн эрсдэл. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Дугуйн эрсдэл/Замын хөдөлгөөнт оролцож байх үед хурц ирмэгтэй зүйлд зүсэгдэх ,урагдах байдлаар дугуйнд учирсан хохирол.Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Нэмэлт тоноглол хэрэгсэлд учирсан хохиролын эрсдэл. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Дугуйнаас үүдэн гарсан хохирол. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Хэрвээ энэ бүх эрсдэл даатгуулагчийн буруугаас гарсан бол. Эрсдэлийн хамгаалалт 100 хувь байна.
- Даатгуулагчийн хариуцах хэсэг байхгүй.

3.1 Төслийн менежер нь *[томилогдсон этгээдийн нэр, хаяг]*

4.1 Ажил эхлэх өдөр: 2020.05.27

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр :2021.05.28 ⁴

5.1 Автомашины тоо болон сери дугаар өөрчлөгдсөн тохиолдолд талууд харилцан тохиролцож болно.

7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш *[5]* хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

9.1 Чанарын баталгаат хугацаа 1 жил байна.

13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн *[хувь]* байна.⁵

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн *[хувь]* байна.

17.1 Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг *[огноо]*-ны дотор гаргаж өгнө.

Гүйцэтгэлийн зургийг *[огноо]*-ны дотор гаргаж өгнө.

Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ *[мөнгөн дүн]* байна.

19.1

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Тав. Техникийн тодорхойлолт

Улсын дугаар	Марк	Үйлдвэрлэсэн он	Зориулалт	Арлын дугаар	Даатгалын үнэлгээ	Хураамжийн хувь	Даатгалын хураамж
01-43 УНҮ	Ниссэн Инфенети QX-80	2019	Суудлын	JN8AZ2NC9K9460513	319 000 000		
00-91 УНҮ	Ниссэн Патрол Y-62	2019	Суудлын	JN1TANY62Z0110437	210 000 000		
00-69 УНҮ	Лекус – 460	2011	Суудлын	JTHGM46F705031723	85 000 000		
35-26 УНП	Лекус – 570	2012	Суудлын	JTJHY00W3B4078118	100 000 000		
00-06 УБЗ	Тоёота Ланд крузер - 200	2007	Суудлын	JTMHT05J504000953	75 000 000		
26-00 УБЕ	Тоёота Ланд крузер - 105	2004	Суудлын	JTECJ09JX05509548	35 000 000		
01-62 УНҮ	Ниссэн Патрол Y-61	2010	Суудлын	JN1TCSY61Z0571863	70 000 000		
01-12УНҮ	Ниссэн Алтима	2019	Суудлын	1N4BL4EV3KC103836	86 550 960		
01-22УНҮ	Ниссэн Алтима	2019	Суудлын	1N4BL4EV1KC103253	86 550 960		
01-32УНҮ	Ниссэн Алтима	2019	Суудлын	1N4BL4EV1KC124329	86 550 960		
03-48УНҮ	Ниссэн Алтима	2019	Суудлын	1N4BL4EV0KC104801	86 550 960		
01-72УНҮ	Ниссэн Урбан	2019	Суудлын	JN1VB4E26Z0015064	79 900 000		
01-81 УНҮ	Хьюндай Старекс Н-1	2010	Суудлын	KMJWA37RAAU242115	28 000 000		
47-03УБЛ	Хьюндай Коунти	2012	Суудлын	KMJHG17FPCC055193	75 000 000		
74-09 УБЗ	Тоёота Кэмри	2012	Суудлын	6T1BF9FK3D435287	32 000 000		
01-42 УНҮ	Тоёота Кэмри	2012	Суудлын	6T1BF9FK5D436375	32 000 000		
31-44 УАЕ	Исузу NMR	2018	Ачааны	JAANMR71HJ7111707	91 400 000		
					1 578 503 840		

Жолооч нарын мэдээлэл:

Д/д	Улсын дугаар	Марк	Жолоочын нэр	Регистрийн дугаар	Ангилал	Жолооч болсон огноо	Жолооны үнэмлэхний дугаар
1.	01-43 УНУ	Инфенети QX-80	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609
2.	00-91 УНУ	Ниссэн Патрол Y-62	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609
3.	00-69 УНУ	Лексус – 460	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609
4.	35-26 УНП	Лексус – 570	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609
5.	00-06 УБЗ	Тоёота Ланд крузер - 200					
6.	26-00 УБЕ	Тоёота Ланд крузер - 100					
7.	01-62 УНУ	Ниссэн Патрол Y-61					
8.	01-12УНУ	Ниссэн Алтима	Г.Ганбаяр	Ч383112777	ВСДЕ	2002	
9.	01-22УНУ	Ниссэн Алтима	Н.Сухбаатар	ОН83020274	ВСДЕ	2004	370533
10	01-32УНУ	Ниссэн Алтима	Э.Лхагвасүрэн	ЧФ75020510	В	2004	340675
11	03-48УНУ	Ниссэн Алтима					
12	01-72УНУ	Ниссэн Урбан					
13	01-81 УНУ	Хьюндай Старекс Н-1	С.Баянмөнх	Ш366123012	ВСДЕ	1990	2645
14	47-03УБЛ	Хьюндай Коунти	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609
15	74-09 УБЗ	Тоёота Кэмри	С.Баянмөнх	Ш366123012	ВСДЕ	1990	2645
16	01-42 УНУ	Тоёота Кэмри					
17	31-44 УАЕ	Исузу NMR	М.Рэнцэндорж	BM67110317	ВСДЕ	1986	61609

Зургаа. Зураг

Долоо. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Найм. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай
_____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо
метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____
хана, _____ хучилттай,

- 5.
- 6.
- 7.
- 8.
- 9.

10. _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

11. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 11.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 11.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 11.3. Үнийн санал
- 11.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 11.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 11.6. Техникийн тодорхойлолт;
- 11.7. Зураг;
- 11.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 11.9. Санхүүжилтийн хуваарь;
- 11.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

12. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

13. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

14. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

15. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын

[Гарын

үсэг] _____

үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]